



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 12 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 487

Улаанбаатар  
хот

Төрийн захиргааны албан тушаалын ангилал,  
зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг  
шинэчлэн батлах тухай


Төрийн албаны тухай хуулийн 10.4, 18.8 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн саналыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 375 дугаар тогтоолын 3 дахь заалт, мөн “Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны бүтэц, аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны орон тооны хязгаарыг тогтоох тухай” Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 376 дугаар тогтоолын 4 дэх заалтын “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2019 оны 275 дугаар тогтоол” гэснийг “Засгийн газраас баталсан төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалт” гэж тус тус өөрчилсүгэй.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 275 дугаар тогтоол, “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2020 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 184 дүгээр тогтоол, “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 194 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэ тогтоолыг 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.




Монгол Улсын Ерөнхий сайд

Хөдөлмөр, нийгмийн  
хамгааллын сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Т.АЮУРСАЙХАН



Засгийн газрын 2022 оны 487 дугаар  
тогтоолын хавсралт

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ,  
ТҮҮНД ХАМААРАХ АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ

Төрийн захиргааны албан тушаалын ангилал	Тухайн ангилалд хамаарах албан тушаалын товч тодорхойлолт	Төрийн захиргааны албан тушаалын зэрэглэл	Төрийн захиргааны албан тушаал			
			Төрийн захиргааны төв байгууллага, түүний харьяа агентлаг, бусад байгууллагын албан тушаал		Нутгийн захиргааны байгууллагын албан тушаал	
			Удирдах	Гүйцэтгэх	Удирдах	Гүйцэтгэх
1	2	3	4	5	6	7
Тэргүүн түшмэл	Засгийн газрын үйл ажиллагааны зохих салбарын бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй байгууллагын ажлын гүйцэтгэл, үр дүнг Засгийн газрын гишүүний өмнө хариуцна. Байгууллагын төсөв болон төрийн тусгай сангийн удирдлага, санхүүжилтийн талаар хариуцлага хүлээнэ.	ТЗ-1	1.Яамны Төрийн нарийн бичгийн дарга  2.Засгийн газрын агентлагийн дарга		1.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга  2.Нийслэлийн Засаг даргын тамгын газрын дарга  3.Улаанбаатар хотын Ерөнхий менежер	

Эрхэлсэн түшмэл	Засгийн газрын үйл ажиллагааны зохих салбар, салбар дундын хүрээний асуудалд дүн шинжилгээ хийж бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллага, нэгжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж	ТЗ-2	<p>1.Яамны газрын дарга</p> <p>2.Засгийн газрын агентлагийн дэд дарга</p> <p>3.Чөлөөт бүсийн захирагч</p> <p>4.Цөмийн энергийн комиссын ажлын албаны дарга</p> <p>5.Засгийн газраас байгуулсан төрийн захиргааны бусад байгууллагын дарга</p>		<p>1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга</p> <p>2.Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга</p>	
	гүйцэтгэл, үр дүнг тэргүүн түшмэл, төсвийн ерөнхийлөн болон шууд захирагчийн өмнө хариуцна.	ТЗ-3	<p>1.Яамны хэлтсийн дарга</p> <p>2.Засгийн газрын агентлагийн газрын дарга</p> <p>3.Чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны дарга</p> <p>4.Цөмийн энергийн комиссын ажлын албаны газар (хэлтэс)-ийн дарга</p> <p>5.Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын дарга</p>		<p>1.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны хэлтсийн дарга</p> <p>2.Нийслэлийн Засаг даргын тамгын газрын хэлтсийн дарга</p> <p>3.Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны хэлтсийн дарга</p> <p>4.Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нутгийн захиргааны байгууллагын дарга</p>	
Ахлах түшмэл	Засгийн газрын үйл ажиллагааны зохих салбар, салбар дундын хүрээний асуудалд судалгаа, дүн	ТЗ-4	<p>1.Яамны тасгийн дарга</p> <p>2.Засгийн газрын агентлагийн хэлтсийн дарга</p> <p>3.Засгийн газраас</p>	1.Яамны ахлах шинжээч	<p>1.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны тасгийн дарга</p> <p>2.Нийслэлийн Засаг даргын тамгын газрын</p>	

	шинжилгээ хийх, бодлого, шийдвэрийн санал, төсөл боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг хүлээж, ажлын гүйцэтгэл, үр дүнг эрхэлсэн түшмэлийн өмнө хариуцна.		байгуулсан төрийн захиргааны бусад байгууллагын газрын дарга  4.Чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны хэлтсийн дарга  5.Хилийн чанад дахь нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн дарга  6.Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын нарийн бичгийн дарга		тасгийн дарга  3.Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нутгийн захиргааны байгууллагын хэлтсийн дарга  4.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга  5.Дүүргийн Засаг даргын тамгын газрын дарга  6.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны хэлтсийн дарга  7.Аймгийн Засаг даргын тамгын газрын хэлтсийн дарга  8.Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нутгийн захиргааны байгууллагын дарга  9.Нийслэл, аймаг дахь Төрийн албаны Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга	
		T3-5	1.Засгийн газраас байгуулсан төрийн захиргааны бусад байгууллагын хэлтсийн дарга  2.Хилийн чанад дахь	1.Яамны шинжээч	1.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга  2.Сумын Засаг даргын тамгын газрын дарга	

			<p>нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн тасгийн дарга</p> <p>3.Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны дарга</p> <p>4.Сав газрын захиргааны дарга</p>			
Дэс түшмэл	Засгийн газрын үйл ажиллагааны зохих салбар, салбар дундын хүрээний тодорхой асуудлаар бодлого, шийдвэрийн санал, төсөл боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах үүрэг хүлээж, ажлын гүйцэтгэл, үр дүнг ахлах түшмэл, төсвийн шууд захирагчийн өмнө хариуцна.	T3-6		<p>1.Яамны ахлах мэргэжилтэн</p> <p>2.Засгийн газрын агентлагийн Улсын ахлах байцаагч</p> <p>3.Засгийн газрын агентлагийн ахлах мэргэжилтэн</p> <p>4.Цөмийн энергийн комиссын ажлын албаны ахлах мэргэжилтэн</p> <p>5.Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн ерөнхий нягтлан бодогч</p>	<p>1.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны хэлтсийн дарга</p> <p>2.Дүүргийн Засаг даргын тамгын газрын хэлтсийн дарга</p> <p>3.Дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтсийн дарга</p> <p>4.Аймгийн Засаг даргын тамгын газрын тасгийн дарга</p> <p>5.Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нутгийн захиргааны байгууллагын хэлтсийн дарга</p> <p>6.Улсын зэрэглэлтэй хотын Захирагчийн ажлын албаны дарга</p>	<p>1.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны ахлах мэргэжилтэн</p> <p>2.Нийслэлийн Засаг даргын тамгын газрын ахлах мэргэжилтэн</p> <p>3.Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны ахлах мэргэжилтэн</p> <p>4.Аймаг, нийслэлийн төсвийн ерөнхий нягтлан бодогч</p> <p>5.Улсын ахлах байцаагч, ахлах дотоод аудитор</p>
		T3-7	1.Сав газрын захиргааны хэлтсийн дарга	<p>1.Яамны мэргэжилтэн</p> <p>2.Засгийн газрын агентлагийн Улсын байцаагч</p>	<p>1.Дүүргийн Засаг даргын тамгын газрын тасгийн дарга</p> <p>2.Дүүргийн Засаг даргын</p>	<p>1.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны</p>

				<p>3.Засгийн газрын агентлагийн мэргэжилтэн</p> <p>4.Чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны ахлах мэргэжилтэн</p> <p>5.Цөмийн энергийн комиссын ажлын албаны мэргэжилтэн</p> <p>6.Хилийн чанад дахь нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн ахлах мэргэжилтэн</p> <p>7.Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын мэргэжилтэн</p>	<p>дэргэдэх хэлтсийн тасгийн дарга</p>	<p>мэргэжилтэн</p> <p>2.Нийслэлийн Засаг даргын тамгын газрын мэргэжилтэн</p> <p>3.Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны мэргэжилтэн</p> <p>4.Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нутгийн захиргааны байгууллагын ахлах мэргэжилтэн</p> <p>5.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны ахлах мэргэжилтэн</p> <p>6.Дүүргийн Засаг даргын тамгын газрын ахлах мэргэжилтэн</p> <p>7.Дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтсийн ахлах мэргэжилтэн</p> <p>8.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны ахлах мэргэжилтэн</p> <p>9.Аймгийн Засаг</p>
--	--	--	--	--	--	---

						<p>даргын газрын мэргэжилтэн</p> <p>тамгын ахлах мэргэжилтэн</p> <p>10.Улсын зэрэглэлтэй Захирагчийн албаны мэргэжилтэн</p> <p>хотын ажлын ахлах мэргэжилтэн</p> <p>11.Сум, төсвийн нягтлан бодогч</p> <p>дүүргийн ерөнхий</p> <p>12.Улсын байцаагч, дотоод аудитор</p> <p>13.Төрийн ахлах мэргэжилтэн</p> <p>сангийн</p> <p>14.Аймгийн даргын асуудлын боловсрол, шинжлэх ухааны хариуцсан захиргааны байгууллагын арга зүйч</p> <p>Засаг эрхлэх хүрээний нутгийн ахлах</p>
		T3-8		<p>1.Яамны ахлах зохион байгуулагч</p> <p>2.Засгийн газраас байгуулсан төрийн захиргааны бусад байгууллагын ахлах мэргэжилтэн</p> <p>3.Чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны мэргэжилтэн</p>	<p>1.Тосгоны захирагчийн ажлын албаны дарга</p>	<p>1.Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нутгийн захиргааны байгууллагын мэргэжилтэн</p> <p>2.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны мэргэжилтэн</p>

				<p>4.Хилийн чанад дахь Нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн мэргэжилтэн</p> <p>5.Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны ахлах мэргэжилтэн</p> <p>6.Сав газрын захиргааны ахлах мэргэжилтэн</p>		<p>3.Дүүргийн Засаг даргын тамгын газрын мэргэжилтэн</p> <p>4.Дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтсийн мэргэжилтэн</p> <p>5.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны мэргэжилтэн</p> <p>6.Аймгийн Засаг даргын тамгын газрын мэргэжилтэн</p> <p>7.Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нутгийн захиргааны байгууллагын ахлах мэргэжилтэн</p> <p>8.Улсын зэрэглэлтэй хотын Захирагчийн ажлын албаны мэргэжилтэн</p> <p>9.Аймгийн зэрэглэлтэй хотын Захирагчийн ажлын албаны ахлах мэргэжилтэн</p> <p>10.Төрийн сангийн мэргэжилтэн</p>
--	--	--	--	---	--	---

						11.Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний боловсрол, шинжлэх ухааны асуудал хариуцсан нутгийн захиргааны байгууллагын арга зүйч
		T3-9		<p>1.Засгийн газраас байгуулсан төрийн захиргааны бусад байгууллагын мэргэжилтэн</p> <p>2.Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны мэргэжилтэн</p> <p>3.Сав газрын захиргааны мэргэжилтэн</p>		<p>1.Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нутгийн захиргааны байгууллагын мэргэжилтэн</p> <p>2.Аймгийн зэрэглэлтэй хотын Захирагчийн ажлын албаны мэргэжилтэн</p> <p>3.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны мэргэжилтэн</p> <p>4.Сумын Засаг даргын тамгын газрын мэргэжилтэн</p> <p>5.Тосгоны захирагчийн ажлын албаны мэргэжилтэн</p> <p>6.Хорооны нийгмийн ажилтан</p> <p>7.Хорооны бүртгэл</p>

						мэдээлэл, зохион байгуулалтын асуудал хариуцсан ажилтан  8.Сумын нийгмийн ажилтан  9.Газрын даамал  10.Байгаль хамгаалагч
Туслах түшмэл	Бодлого, шийдвэр боловсруулахад дэмжлэг үзүүлж, холбогдох судалгаа, мэдээллээр хангаж, ажлын гүйцэтгэл, үр дүнг нэгжийн дарга, төсвийн шууд захирагчийн өмнө хариуцна.	T3-10		1.Яамны байгуулагч  2.Засгийн агентлагийн байгуулагч	зохион  газрын зохион	1.Багийн нийгмийн ажилтан  2.Багийн зохион байгуулагч